

“Тогтвортой хөгжил” (“Sustainable Development”) загварын тухай зарим санаа

Б.Жадамбаа

“Sustain” - ухагдахууны тайлбар:

- Юм, үзэгдэл амьдрах, оршин байх хүрэлцэхүйц зүйлээр хангагдах;
- Алив зүйл ямар нэг юм шаардахгүйгээр удаан хугацаанд үргэлжилж байх;
- Үргэлжлүүлсээр байх, тууштай баримтлах, тамир тэнхээ буюу сэтгэлийн дэм өгөх, хүлээн зөвшөөрөх;
- Тасрахгүй буюу тасралтгүй байх, юм, үзэгдэл ба хам хүрээг нэгдэлд нь буюу шүтэлцэн багцрахууд нь авч үзэх (Б.Ж)

“Sustianable” хэмээх ухагдахууны тайлбар:

- Байгалийн бүтээгдэхүүн, эрчим хүчийг хүрээлэн буй орчинд хор хохирол учруулахгүйгээр ашиглах;
- Тухайн юм, үзэгдэл удаан хугацааны турш үргэлжилж байх буюу үргэлжлэх;
- Тулхтай, тууштай, тогтвортой;
- Тасралтгүй, үргэлжилсэн, хам хүрээтэйгээ нэгдсэн, нөхцөлдсөн, шүтэн багцарсан (Б.Ж);
- “Sustainable = sustain + able” гэдгээс тогтонги байх, үргэлжлэх, хам хүрээтэйгээ нэгдэлтэй байх чадавх (Б.Ж)

“Sustianability” хэмээх ухагдахууны тайлбар:

- Байгалийн бүтээгдэхүүн, эрчим хүчнийг хүрээлэн буй орчинд хор хохиролгүйгээр ашиглахуй;
- Тухайн юм, үзэгдэл удаан хугацааны турш дахь үргэлжилж байхуйбуюу үргэлжилэхүй;
- Тулх, тууш, тогтворшил;
- Үргэлжлэх буюу тасралтгүй байх чадавх (Б.Ж);
- Хам хүрээших буюу хүрээлэн буй бодот орчинд нутагших, түүнтэй нэг болох, нэгдэх, зохицох чадавх (Б.Ж) гэх мэт.

“Development” гэдэг ухагдахууны тайлбар

- Бүтээл, бүтээн босголт; өсөлт хөгжил, дэгжилт, хөгжил(т), тохижилт; ололт амжилт; хэрэг явдал, нөхцөл байдал, хөгжүүлэх, дэлгэрүүлэх;
- Хөгжлийн Хөгжих үйл, түүний үр
- Хувьсах үйл, түүний үр
- Өөрчлөгдөх үйл, түүний үр

“Sustianable Development” гэдэг ухагдахууны тайлбар:

- “...хамгийн эрхэм сайхан зорилгод хүрэхийн тулд өвөг дээдсээ, мөн өөрийгөө бусдыг, түүнчлэн өнгөрсөнөө мөн өнөөдөр болон ирээдүйгээ золиослохгүйгээр ажиллаж, амьдрах арга ухаан дээдэлсэн аж төрөх соёл...”
- Тогтвортой хөгжил
- Үргэлжилсэн буюу үргэлжилж буй хөгжил (Б.Ж)
- Нэгдэлд, нөхцөлдөхүйд, шүтэлцэн багцрахуйд авч үзэж буй хөгжил (Б.Ж)
- Тогтворшсон буюу тогтвортой нөхцөл байдал (Б.Ж)

"Educational Sustianable Development (ESD)" -ухагдахууны тайлбар:

- Тогтвортой хөгжлийн боловсрол
- Боловсрол гэдгийг нэг талаас, хүмүүний сурч хүнших үйл явц, нөгөө талаас, уг үйлийн үр хэмээн ухаарч ухамсарлан, түүнийг хөгжүүлэх асуудлыг Дорны, тухайлбал, Монголчуудын ертөнцийг үзэх үзлийн үүднээс эргэн харж, шинэчлэн өөрчлөхүй, түүний үр (Б.Ж),
- Боловсролын тогтонги буюу тогтвортой болсон, тогтворшсон нөхцөл байдал(Б.Ж)

“Environment” гэдэг ухагдахууны тайлбар:

- Хүрээлэн буй орчин
- Хүрээлэн буй байгаль – нийгмийн нэгдмэл орон
- Алив юм, үзэгдлийн хам хүрээ (context)

Дэлхийн хамтын нийгэмлэг (НҮБ, ЮНЕСКО)-ийн дэмжлэг-тэйгээр манай гаригийн хүмүүс өөрсдийн аж амьдрал, гэр орон болох Дэлхийнхээ өнөөгийн байдалд хамтран шинжилгээ үнэлгээ хийн доорх дүгнэлтэд хүрсэн (1972 -2009):

- Хэдийгээр бид хөгжиж байгаа боловч биднийг хүрээлэн буй орчин маань доройтож байна (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин” сэдэвт хуралдаан, Швед, Стокгольм, 1972).
- Манай гаригийн байгаль, нийгмийн тогтолцоо бүхэлдээ тогтворжиж чадахгүй, дэлхийн экосистемийн доройтол улам нэмэгдсээр байгаа нь өнөөгийн хөгжлийн загварыг (Өрнийн номлол төвтэй загвар, Б.Ж -барууны хөгжлийн загварыг) хадгалах боломжгүй болгож байна. (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Тогтвортой хөгжил нь эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм гэсэн 3 баганатай (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Хүн амын болон үйлдвэрлэлийн өсөлт, сав шим ертөнцийн нөөц чадавхын хязгаарлагдмал байдал болон хөгжилтэй ба хөгжиж буй орнуудын хэрэглээний (улс төр, эдийн засаг, нийгэм, ахуйн) түвшний хэт ялгаатай байдал зэрэг нь хөгжилд зөрчлийг үүсгэж байна. (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Хөгжлийг зөрчилд нь бус, Нэгдэлд нь авч үздэг дорны гүн ухаан төвтэй иргэншлийн шинэ чиг хандлага болох “Тогтвортой хөгжил” загварыг улс орон бүр өөрийн онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Дэлхийн улс орнууд, хүн ард нь дэлхий нийтээрээ харилцан хамааралд оршиж, нийтлэг хариуцлага хүлээдгийг ойлгон ухамсарлах шаардлагатай. (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Боловсролын талаар өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулахгүйгээр хөгжлийн шинэ чиг хандлага буюу загварыг хэрэгжүүлж чадахгүй. (НҮБ-ын “Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, эдийн засгийн ба Нийгмийн хөгжил, хүрээлэн буй орчны хамгаалал гэсэн тогтвортой хөгжлийн 3 бүрдэл хэсгийг интеграцчлах үйл явцыг дэмжих чухал. (НҮБ-ын “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн их чуулган” сэдэвт олон улсын дээд хэмжээний уулзалт, Африк, Иоханнесбург, 2002)
- Байгальтайгаа зохицож, байгалийн хуулийг дагаж амьдардаг Дорно дахины үзэл, философи нь тогтвортой хөгжлийн үндэс юм. (НҮБ-ын “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн их чуулган” сэдэвт олон улсын Дээд хэмж: уулзалт, Африк, Иоханнесбург, 2002)

Тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол – хүн төрөлхтний, тухайлбал, боловсролын хөгжлийн шинэ чиг хандлагыг илэрхийлж байна.

Хөгжлийн шинэ чиг хандлагыг НҮБ, ЮНЕСКО-ийн тулгуур баримт бичгүүдэд дараах байдлаар тодорхойлсон байна.


- Экологи ба хөгжил гэсэн ойлголтыг уялдаа холбоонд нь авч үзэх (НҮБ-ын "Хүний хүрээлэн буй орчин" сэдэвт хуралдаан, Швед, Стокгольм, 1972)
- Өөрийн гаригийн байгаль, нийгмийн тогтолцоог нэгдэлд нь буюу иргэншлийн шинэ чиг хандлага болох "Тогтвортой хөгжил" загварын хүрээнд авч үзэх (НҮБ-ын "Хүний хүрээлэн буй орчин ба хөгжил" сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалт, Бразил, Рио-Де Жанейро, 1992)
- Хөгжлийн шинэ чиг хандлагын буюу "Тогтвортой хөгжил" загварын үзэл, номлолын үндэс нь "аливааг зөрчилд нь бус нэгдэлд нь авч үздэг" Дорно дахины гүн ухаан гэдгийг тооцох (НҮБ-ын "Даян Дэлхийн тогтвортой хөгжлийн их чуулган" сэдэвт олон улсын Дээд хэмжээний уулзалт, Африк, Иоханнесбург, 2002)
- Бүх түвшний алив зүйлсийн хөгжлийн (хувьслын, өөрчлөлтийн, шинэчлэлийн, төгөлдөршлийн гэх мэт) асуудлыг "Тогтвортой хөгжил" загварын буюу үзлийн үүднээс авч үзэх (НҮБ-ын "Хүний хүрээлэн буй орчин" сэдэвт хуралдаан, Швед, Стокгольм, 1972, "Хөгжлийн хөтөлбөр - 21")
- "Тогтвортой хөгжил" загварыг буюу үзлийг хэрэгжүүлэх ажлын үндэс нь тогтвортой хөгжлийн боловсрол болохыг тооцох (НҮБ-ын "Хүний хүрээлэн буй орчин" сэдэвт хуралдаан, Швед, Стокгольм, 1972, "Хөгжлийн хөтөлбөр -21")
- "Тогтвортой хөгжлийн боловсрол нь бидний ирээдүйдээ оруулж буй хөрөнгө оруулалт" учраас улс орон бүр ашиглаж буй нөөцүүдээ өөрийн орны тогтвортой хөгжлийн боловсролын хөгжилд зориулах ёстой. (НҮБ-ын "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн Их чуулган" сэдэвт олон улсын Дээд хэмжээний уулзалт, Африк, Иоханнесбург, 2002, "Иоханнесбургийн тунхаглал")
- "Тогтвортой хөгжлийн боловсрол гэдэг нь хүн бүр боловсролын бүхий л боломжуудаас үр ашиг хүртэх, тогтвортой ирээдүйг цогцлоон бүтээхэд шаардлагатай амьдралын хэв маяг, зан үйл, үнэт зүйлст суралцах боломжтой ирээдүйн Дэлхий ертөнцийг бий болгохын тулд улам бүр эрч хүч авч, өргөжин тэлж байгаа үйл ажиллагаа юм" (НҮБ-ын Ерөнхий ансамблейн шийдвэрээр баталсан ЮНЕСКО-гийн "Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жил (2005-2014)" хөтөлбөр, ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Кончиро Мацура, 2004)

...үргэлжлэл:

- “Боловсролоор дамжуулан хүн төрөлхтний аж байдлыг экологийн цэвэр орчин, эдийн засгийн шударга байдал, тогтвортой аж төрөх ёс болон бүх амьд амьтад харилцан шүтэлцээтэй амьдрах боломжийг бий болгох асуудлыг шийдвэрлэж, бэрхшээлийг давж, соёлын олон талт онцлогуудыг хүндэтгэн бие биенээ гэсэн тайван нийгмийг бий болгож чадна” (“Байгаль орчны олон улсын 4 дүгээр бага хурал”, Энэтхэг, Ахмадабад, 2007)

Өөрчлөлт шинэчлэлийн бодит байдал






Шинэ чиг хандлага буюу загварыг хэрэгжүүлэх үйл явц дахь стратегийн хоёр хувилбар:


- Алив зүйлийг хөгжүүлэх төсөл, Хөтөлбөр хэрэгжүүлээд гарсан үр дүнг тогтворжуулах замаар төгөлдөршил бий болгох;
- Дөрвөн "to be" -ийн хэрэгцээг хангахуйц боловсрол эзэмшүүлэх замаар тогтвортой хөгжлийн боловсролын үзлийг хэрэгжүүлэх;
- Нэг (төсөл) буюу нэг салбарын (хөтөлбөр) асуудлыг шийдэх хандлагыг өргөтгөн салбар дундын хандлага болгох;



- Алив зүйлийн хөгжлийг тэр хүрээлэн буй байгаль нийгмийн нэгдмэл орчны буюу орны салшгүй нэг хэсэг буюу төлөв байдал хэмээн үзэж хэрэгжүүлэн тогтворжилтыг бий болгох;
- Боловсролд Дорны, тухайлбал, Монголын уламжлалт ертөнцийг үзэх үзлийн үүднээс хандан өөрчлөн шинэчилж, хүмүнд эзэмшүүлэн түүнийг шууд хэрэгжүүлэх нөхцөл боллоцоог бүрдүүлэх замаар тогтвортой хөгжлийн боловсролын үзлийг ажил хэрэг болгох;
- Алив асуудалд салбар дундын болж өргөжин тэлсэн хандлагын үүднээс хандах;

Хөгжлийн тогтворжилт (Sustainable Development) ↔ Тогтвортой хөгжил (Sustainable Development)





Экологи – арга болох байгалийн ба билиг болох нийгмийн экологийн шүтэлцэн багцрахуй учраас бид:

- Хүрээлэн буй орчинг- арга болох байгалийн ба билиг болох нийгмийн нэгдмэл орчинг буюу орны нэгдэл,
- Хүрээлэн буй орчны доройтлыг – байгалийн ба нийгмийн нэгдмэл орчны доройтол,
- Экологийн тэнцвэргүй байдлыг – байгалийн ба нийгмийн экологийн тэнцвэргүй байдал хэмээн тус тус ойлгох хэрэгтэй

Гэвч өнөөдөр эдгээр асуудлыг мөн л “Өрнийн буюу аргын сэтгэлгээ”- ний талаас нь авч үзэн зөвхөн арга болох “байгаль” талаас нь авч үзсээр байна.

Хүмүүний тогтвортой хөгжлийн боловсролын талаарх Монгол ухаан: бие -сэтгэцийн нэгдэл болох хүмүн (хам шинж) тухайн агшин дахь өөрийгөө хүрээлэн буй байгаль-нийгмийн нэгдмэл оронтойгоо (хам хүрээ) нэг болох буюу нэгдэх үйл (ТХБболовсролшихуй), түүний үр (ТХБ)



ДҮГНЭЛТ

- Хүмүн төрөлхтний соёл — иргэншлийн төв 1972 оноос эхлэн Өрнөөс Дорно уруу шилжиж эхэлсэн.
- Энэхүү шилжилтийг хүмүн төрөлхтөн Дэлхийн хамтын нийгэмлэгийн санаачилга, дэмжлэгийн тусламжтайгаар “Тогтвортой хөгжил” хэмээх шинэ хандлага буюу загварын хүрээнд хийж байна.
- Гэхдээ мөн л асуудалд аргын сэтгэлгээний үүднээс хандан нэлээд алдаатайгаар хэрэгжүүлж байна. Учир нь Дорныхон бид нөгөө л олон зуун жил даган дуурайж, хуулбарласан зангаараа “төрмөл билгийн сэтгэлгээ үгүй” тэднийг дагаж байна.
- Цаашид Дорныхон, тэр дундаа Монголчууд бид бүтээлчээр ихээхэн чармайлт гарган ажиллаж, өөрсдийн ертөнцийг үзэх үзэлдээ түшиглэн “Тогтвортой хөгжил” чиг хандлагыг эргэн харж сайжруулах шаардлагатай байна. Энэ нь дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Тогтвортой хөгжил” загварыг ажил хэрэг болоход ихээхэн тус дэмтэй зүйл болох нь ойлгомжтой.